



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/61/НА-СТА-ТХН

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор:

Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Долгорсүрэн

Утас: 261885 Цахим хаяг: dolgorsuren.b@audit.mn

Ахлах аудитор: Ж.Мөнхтуул

Утас: 261740 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Сүлд-Аудит" ХХК-ийн захирал:

Ч.Гүндбаяр

Утас: 70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 07/599
танай _____-ны № _____-т

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Б.СУГАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд 2023 онд Завхан аймгийн Улиастай сумын 2 дугаар сургуулийн дулааны насосын систем, Говь-Алтай аймгийн Есөн булаг сумын 10 МВт нарны цахилгаан станц, Завхан аймгийн Тэлмэн дэд станцад шинээр 10 МВАр SVG суурилуулах ажил дуусаж, ашиглалтад хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Төслийн хүрээнд хэрэгжиж буй салхины цахилгаан станцыг Алтай Улиастайн эрчим хүчний системд холбох 4 хувилбарыг тооцоолж, судалгааны үр дүнд Тайшир салхин цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэхгүй байхыг зөвлөмж болгосон. Учир нь:

- Салхины цахилгаан станцын хүчин чадал 13.6 МВт, нийт хөрөнгө оруулалт 21.3 сая ам.доллар;
- Нэгж кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх өртөг 6.3 цент ам.доллар;
- Салхин турбины жилийн дундаж цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 28 сая.кВтц болж салхины цахилгаан станцын чадлын фактор 23 хувь болсон.

Иймд нөхцөл байдлыг Төслийн удирдах хорооны 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар танилцуулан салхин цахилгаан станцын төслийг нарны цахилгаан станцын төсөл болгон өөрчлөх шийдвэр гаргасан байна.

Бусад асуудлын хэсэг

Төслийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 1 хөтөлбөр, 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 39 багц ажлыг төлөвлөснөөс 81.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	51,441,861,327.17	66,933,352,336.44
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	2,221,815,792.35	3,421,972,963.98
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,221,815,792.35	3,421,972,963.98
3121	Төгрөг	17,259,357.34	12,530,560.27
31210	Төрийн сангийн харилцах	17,259,357.34	12,530,560.27
3122	Гадаад валют	2,204,556,435.01	3,409,442,403.71
312210	Төрийн сангийн харилцах ам/доллар	2,204,556,435.01	3,409,442,403.71
34	УРЬДЧИЛГАА	3,950,500.00	3,950,500.00
34600	Урьдчилж гарсан зардал	3,950,500.00	3,950,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	49,216,095,034.82	63,507,428,872.46
351	Дуусаагүй үйлдвэрлэл	49,214,694,434.82	63,506,028,272.46
35400	Хангамжийн материал	1,400,600.00	1,400,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	513,633,978.88	100,128,769.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	513,633,978.88	100,128,769.43
392	Биет хөрөнгө	471,161,127.84	67,475,157.79
39201	Авто тээврийн хэрэгсэл	63,900,000.00	63,900,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,500,000.00)	(46,150,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	560,271,286.07	90,508,027.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(126,950,383.72)	(47,718,982.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,773,376.00	15,773,376.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,925,988.85)	(9,016,030.41)
39213	Бусад хөрөнгө	2,270,200.00	2,270,200.00
39217	Хуримтлагдсан элэгдэл	(1,677,361.66)	(2,091,432.02)
393	Биет бус хөрөнгө	42,472,851.04	32,653,611.64
39301	Программ хангамж	49,096,197.00	49,096,197.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,623,345.96)	(16,442,585.36)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	51,955,495,306.05	67,033,481,105.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	51,955,495,306.05	67,033,481,105.87
51	Засгийн газрын хувь оролцоо	51,955,495,306.05	67,033,481,105.87
512	Хуримтлагдсан үр дүн	51,955,495,306.05	67,033,481,105.87
51210	Өмнөх үеийн үр дүн	14,237,601,928.98	51,955,495,306.05
51220	Тайлант үеийн үр дүн	37,717,893,377.07	15,077,985,799.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	51,955,495,306.05	67,033,481,105.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	39,467,934,099.41	16,428,509,318.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,467,934,099.41	16,428,509,318.70
120	Нийтлэг татварын бус орлого	14,895,960,182.61	15,055,135,402.22
120003	Торгуулийн орлого	5,099,943.76	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,867,878,654.85	15,055,135,402.22
1200041	Зээлийн санхүүжилт	12,633,472,859.56	14,044,062,808.59
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,234,405,795.29	1,011,072,593.63
120009	Бусад орлого	22,981,584.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,571,973,916.80	1,373,373,916.48
131001	Гадаад тусламжийн орлого	24,571,973,916.80	1,373,373,916.48
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,514,843,085.77	871,500,873.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,514,843,085.77	871,500,873.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,514,843,085.77	862,526,083.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,100,000.00	486,158,182.00
210101	Үндсэн цалин	450,100,000.00	486,158,182.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,262,500.00	60,769,772.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,631,880.00	53,723,600.00
210302	Байрны түрээс	49,631,880.00	53,723,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,003,505.73	4,205,771.05
210401	Бичиг хэрэг	2,195,260.00	1,046,870.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,208,245.73	3,158,901.05
210502	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		
210601	Багаж техник хэрэгсэл		
210702	Дотоод албан томилолтын зардал	76,474,400.00	103,006,580.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	779,091,311.75	44,585,836.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,279,488.29	110,076,341.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,683,757.10	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,595,731.19	110,076,341.26
2133	Урсгал шилжүүлэг		8,974,789.99
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		8,974,789.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	37,953,091,013.64	15,557,008,445.40
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	457,688,986.77	
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	457,688,986.77	
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	692,886,623.34	479,022,645.58
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	21,469.46	84,662,898.40
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	25,197,354.52	89,555,878.99
232001	Эргэж төлөгдөх зээл	667,667,799.36	304,803,868.19
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6)=(4)-(5)	(235,197,636.57)	(479,022,645.58)
7	НИЙТ ҮР ДҮН (7)=(3)+(6)	37,717,893,377.07	15,077,985,799.82

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	705,166,436.88	2,136,402,502.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	705,166,436.88	2,136,402,502.68
120	Нийтлэг татварын бус орлого	705,166,436.88	763,116,760.70
120003	Торгуулийн орлого	5,099,943.76	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	668,300,525.12	763,116,760.70
1200041	Зээлийн санхүүжилт	668,300,525.12	763,116,760.70
1200042	Бусад орлого	31,765,968.00	
122	Тусламжийн орлого		1,373,285,741.98
122002	Хандив тусламж /гадаад/		1,373,285,741.98
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	967,619,805.99	761,161,399.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	967,619,805.99	761,161,399.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	967,619,805.99	761,161,399.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,100,000.00	486,158,182.00
210101	Үндсэн цалин	450,100,000.00	486,158,182.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,262,500.00	60,769,772.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,631,880.00	53,723,600.00
210301	Байрны түрээсийн зардал	49,631,880.00	53,723,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,003,505.73	4,205,771.05
210401	Бичиг хэрэг	2,195,260.00	1,046,870.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,208,245.73	3,158,901.05
210604	Дотоод албан томилолт	76,474,400.00	103,006,580.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	301,463,763.16	44,322,704.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,683,757.10	8,974,789.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(262,453,369.11)	1,375,241,102.89
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	605,192,742.18	75,610,744.00
22	Хөрөнгийн зардал	605,192,742.18	75,610,744.00
2200	Барилга байгууламж	543,039,143.16	74,235,744.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	62,153,599.02	1,375,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(605,192,742.18)	(75,610,744.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	457,688,986.77	
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	457,688,986.77	
23	ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		24,939,720.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		24,939,720.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	21,469.46	74,533,467.26
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	21,469.46	74,533,467.26
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	457,667,517.31	(99,473,187.26)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(409,978,593.98)	1,200,157,171.63
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,631,794,386.33	2,221,815,792.35
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,221,815,792.35	3,421,972,963.98

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		14,237,601,928.98	14,237,601,928.98
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		14,237,601,928.98	14,237,601,928.98
C07	Тайлант үеийн үр дүн		37,717,893,377.07	37,717,893,377.07
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		51,955,495,306.05	51,955,495,306.05
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		51,955,495,306.05	51,955,495,306.05
D03	Тайлант үеийн үр дүн		15,077,985,799.82	15,077,985,799.82
D04	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		67,033,481,105.87	67,033,481,105.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,696,700,000.00	14,133,771,296.19	16,562,928,703.81	46.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,721,900,000.00	74,235,744.00	15,647,664,256.00	0.5
220001	Барилга байгууламж	15,721,900,000.00	74,235,744.00	15,647,664,256.00	0.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	14,974,800,000.00	14,059,535,552.19	915,264,447.81	93.9
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	14,974,800,000.00	14,059,535,552.19	915,264,447.81	93.9
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	30,696,700,000.00	15,417,436,725.07	15,279,263,274.93	50.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,974,800,000.00	14,044,062,808.59	930,737,191.41	93.8
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,974,800,000.00	14,044,062,808.59	930,737,191.41	93.8
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	15,721,900,000.00	1,373,373,916.48	14,348,526,083.52	8.7
122002	Хандив тусламж /гадаад/	15,721,900,000.00	1,373,373,916.48	14,348,526,083.52	8.7
	Төсвийн гүйцэтгэлийн тохируулга		(83,508,257.25)		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,221,815,792.35		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,421,972,963.98		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10	10	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ:

Аудитаар нийт 15,146.6 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээний тайлантай холбоотой 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тохируулгын дүн зөрүүтэй	1	8,974.8			1	8,974.8	1	8,974.8				
ХХОАТ-ын тайланг зөрүүтэй тайлагнасан	1	3,120.0			1	3,120.0	1	3,120.0				
Харилцагч байгууллагатай зөрүүтэй дүнгээр тооцоо нийлсэн	1	3,051.8			1	3,051.8	1	3,051.8				
Дүн	3	15,146.6			3	15,146.6	3	15,146.6				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 24,939.7 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснийг албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнгийн 1 мэдээг байршуулаагүй	1	24,939.7			1	24,939.7			
Нийт дүн	1	24,939.7			1	24,939.7			

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,